

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Дархан үйлдвэрлэл технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/6/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.Shinjlenmagadlahui .ezsh.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга	
Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	8
4.1 Ерөнхий зүйл	8
4.2 Материаллаг байдал	9
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	9
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.....	9
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
4.5.1 Завсрын аудитын талаар.....	9
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ДАРХАН УУЛ АЙМАГ ДАРХАН СУМ
"ДАРХАН ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ОНӨААТҮГ**

2025.02.05 № 009
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн "Дархан үйлдвэр технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

"Дархан үйлдвэр технологийн парк" ОНӨААТҮГ нь тайлант онд 5,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 5,531.4 мянган төгрөгийн зардал гарган 531.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020157

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР


2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/


Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	122,355.78	19,191.78
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	34,320.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	122,355.78	53,511.78
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	747,014.92	284,418.60
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	747,014.92	284,418.60
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	869,370.70	337,930.38
2.3.1	Өмч: -төрийн	10,528,740.00	10,528,740.00
2.3.2	-хувийн		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,785,092.06	2,785,092.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(12,444,461.36)	(531,440.32)
2.3.11	Эздийн өмчийн дүн	869,370.70	337,930.38
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	869,370.70	337,930.38



2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

СТ-2А
/Төгрөгөөр/


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого(цэвэр)	25,799,359.57	5,000,000.0
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	25,799,359.57	5,000,000.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	26,788,383.89	5,508,140.3
11	Санхүүгийн зардал	31,050.00	23,300.0
12	Бусад зардал	137,964.57	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-1,158,038.89	-531,440.3
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,158,038.89	-531,440.3
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,158,038.89	-531,440.3



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан


/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	25,730,000.00	5,000,000.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	25,730,000.00	5,000,000.00
	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	29,008,052.22	5,103,164.00
	Ажиллагчдад төлсөн	17,077,766.80	3,465,644.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,383,306.00	1,025,760.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	282,500.00	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,600,000.00	-
	Татварын байгууллагад төлсөн	3,033,429.42	348,460.00
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	631,050.00	263,300.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,278,052.22	-103,164.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-3,278,052.22	-103,164.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,400,408.00	122,355.78
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	122,355.78	19,191.78



2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийг дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,528,700.00	2,785,100.00	(11,286,422.47)	2,027,409.59
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	10,528,700.00	2,785,100.00	(11,286,422.47)	2,027,409.59
4	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(1,158,038.89)	(1,158,038.89)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2024 оны 01 -р сарын 01 -ний үлдэгдэл	10,528,740.00	2,785,092.06	(12,444,461.36)	869,370.70
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	10,528,740.00	2,785,092.06	(12,444,461.36)	869,370.70
12	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(531,440.32)	(531,440.32)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2024 оны 12 -р сары 31-ний үлдэгдэл	10,528,740.00	2,785,092.06	(12,975,901.68)	337,930.38



2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны		/Төгрөг/	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	25,799,359.57	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
	Үүнээс: Цэвэр борлуулалт	25,799,359.57	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
2	Нийт зардал	26,957,398.46	5,531,440.32	5,531,440.32	-	100.0
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	26,957,398.46	5,531,440.32	5,531,440.32	-	100.0
3	Цэвэр ашиг, алдагдал	(1,158,038.89)	(531,440.32)	(531,440.32)	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан үйлдвэр технологийн парк нь Шинжлэх ухаан технологийн парк, Үйлдвэрлэл технологийн парк, Мэдээлэл технологийн парк, Агротехнологийн парк, Биотехнологийн парк, Нанотехнологийн парк гэсэн байдлаар хөгжих зорилго тавин дараах зорилтуудыг тавин ажилладаг. Үүнд:

- Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд шинэ дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах;
- Экспортын бүтээгдэхүүнийг болон импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих;
- Үйлдвэрлэлийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Байгаль орчинд халгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Ажлын байрыг олноор бий болгох;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

"Дархан үйлдвэрлэл технологийн парк" ОНӨААТҮГ нь Засгийн газрын 2006 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 173 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах..." гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дархан үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

“Дархан үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2021 онд мэргэшсэн нягтлан бодогч Ш.Отгоны боловсруулсан НБББББ-ыг мөрдөн ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Дархан үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	122.4	19.2	(103.1)
Авлага	-	34.3	(34.3)
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	747.00	284.4	(462.5)
Нийт хөрөнгө	869.4	337.9	(531.5)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	869.4	337.9	(531.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	869.4	337.9	(531.5)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 103.1 мянган төгрөгөөр буурсан нь 5,000.0 мянган төгрөгийн орлого олж, 5,103.1 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,079.9 мянган төгрөг байна. Тайлант онд нэмж авсан хөрөнгө, акталсан хөрөнгө байхгүй байна.

Авлага НДШ-ийн 34.2 мянган, Өр төлбөр дансны үлдэгдэлгүй ажилласан байна.

Хуримтлагдсан ашиг 12,975.9 мянган төгрөг болж 531.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашиг буурсантай холбоотой байна.

3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Дархан үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 670 дугаар тогтоолоор “Дархан үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг

баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 5,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 5,531.4 мянган төгрөгөөр, алдагдлыг 531.4 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 5,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 5,531.4 мянган төгрөгийн зардал гарган 531.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2024 онд үйл ажиллагаанд зарцуулахаар 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 5,531.4 мянган төгрөг болж төлөвлөсний дагуу ажилласан байна.

Тайлант онд 531.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант онд 5,531.4 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал төлөвлөснөөс цалингийн зардалд 4,294.9 мянган төгрөг, аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардалд 510.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдэлд 462.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ 240.0 мянган төгрөг, банкны шимтгэлд 23.3 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу "Дархан үйлдвэрлэл технологийн парк" ОНӨААТҮГ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

"Дархан үйлдвэрлэл технологийн парк" ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Шинжлэн магадлахуй ЭЗШ" аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу

илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 26,957.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 539.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

.....

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

"Дархан үйлдвэрлэл технологийн парк" ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

"Дархан үйлдвэрлэл технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил байхгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.